



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 536

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 78,110,351.00 (далан найман сая нэг зуун арван мянга гурван зуун тавин нэг) төгрөгийн балансын үнэ, 18,678,562.27 (арван найман сая зургаан зуун далан найман мянга таван зуун жаран хоёр төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Гэрэлсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэн ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталсан барилгын доорх газрыг Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн мэдэлд хэвээр үлдээж, нөхөн сэргээх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133002365
23-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 он 09 дугаар сарын 10-ны өдрийн
53.6 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэ г/	Балансын нийт үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Эхчүүдийн амрах байрны барилга	1985	1	78,110,351.00	18,678,562.27	59,431,788.73
НИЙТ ДҮН			1	78,110,351.00	18,678,562.27	59,431,788.73
				(далан найман сая нэг зуун арван мянга гурван зуун тавин нэгэн төгрөг)	(арван найман сая зургаан зуун далан найман мянга таван зуун жаран хоёр төгрөг хорин долоон мөнгө)	(тавин есөн сая дөрвөн зуун гучин нэгэн мянга долоон зуун наян найман төгрөг далан гурван мөнгө)